

МОНГОЛ ХУВЦСЫГ СУДАЛСАН БАЙДАЛ

Л.Долгоржав*, ОИС

Abstract

As our forefathers developed handmade science for common usage and clothing while living as a nomads and moving around vast pastures from ancient years and have been inhering for their youths which consequently gained an enriched found.

Mongolian traditional clothes have a special feature that is coherence with Mongolian nature, climate, people's lifestyle, pattern, habit, mind, respecting cultural frame and social regulations and codes that were firmly adhered by the locals. Especially, the figure and appearance of Mongolian traditional clothes become the core sign that distinguishes the ethnicity from other nationalities, but also they present the standards of ceremony, ordinance and moral.

Researchers and scholars have been studying about how human being faced with clothing and wearing demand from ancient time, how the accessories developed and being changed throughout years from diversified view. As shown in their researches, Mongolian outlet history belonged to before XIII century, has feature that clothing was differentiated based on their positions, ranks, ethnic groups that contributed to their various histories.

Feature, design, clothing code, using culture of various ethnic group, ethnic group history to wear clothes, ethnography, archeology and art of making the Mongolian traditional clothes have been researched in detail.

For the studies about Mongolian traditional clothes, main dell, boots, hat researches had been researched, and the clothes that are distinguished accordingly by race, decoration, equipment researches, archeological findings have been analyzed. Also, for the multi-national and ethnic clothes and outlet, there are few researches about the dialect of those who named their clothes.

However, although the scholars mainly explored about Mongolian clothes related with their history, ethnography and methods to make by sewing with decorations, fewer researches have been done on the language and culture of the clothes, and how the clothes were named.

Түлхүүр үг

Түүх, хэл, соёл, тойм судалгаа, монгол хувцас

Удиртгал

Аливаа үндэстэн, угсаатан ястны эдэлж хэрэглэх хувцас нь хэрэгцээний нэгэн нийтлэг шинж чанартай боловч хүмүүсийн оршин суух, нутаглах газар орон, эрхлэх аж ахуйн соёлтой уялдаж ястан угсаатны бүлэг бүрд ялгаатай байх бөгөөд үүгээрээ үндэстний соёлын нэг хэсгийг илэрхийлж байдаг. Өөрөөр хэлбэл хувцсанд тухайн ард түмний эдэлж хэрэглэх эд зүйл, хэв хэмжээ, дүрэм горим, угсаатан ястны эдийн болон оюуны соёлын онцлог шинж бүрнээ тусгагдсан байдаг.

Монгол үндэсний мөн олон угсаатан ястны хувцас өмсгөлийн зүйл нь Монголчуудын нас хүйсийн байдал, нийгэмд эзлэх байр суурь, хөрөнгө чинээ, угсаа гарал, аж ахуй эрхлэх өвөрмөц арга, түүхэн үйл явдал, байгаль цаг уурын нөхцөл, орчны онцлогийг илэрхийлэх эдийн соёлын үндсэн хэсэг, үнэт хэрэглэгдэхүүн болно.

Эрдэмтэн судлаачид хүн төрөлхтөн анх хувцас өмсөх хэрэгцээ бий болсон эртний үеэс эхлэн орчин цагийн хувцас, гоёл чимэглэлийн зүйл хэрхэн хөгжиж, өөрчлөгдөж ирсэн түүхийг олон талаас нь судалжээ.

Энэхүү өгүүлэлд монгол хувцасны түүх, уламжлал, соёлыг судалсан байдлыг тоймлон, хувцасны талаарх үндэстний соёл, сэтгэлгээний онцлог, хувцас өмсгөлийн холбогдолтой Монгол хэлний олон нэршил түүний утга зэрэг судалгааг тодруулан авч үзэж, цаашид эл төрлийн судалгааг дэлгэрүүлэн судлах хэрэгцээ шаардлага, мөн хэлний талаас хэрхэн хандах, Монгол хувцасны нэршлийн илэрхийлэх утга, билэгдэл, үнэлэмж зэргийг хэл-соёлын талаас хэрхэн судалж болохыг тодорхойлох зорилгоор баримт эх сурвалжид дүн шинжилгээ хийх судалгааны аргыг түлхүү ашигласан болно.

*✉ l.dolgorjav@yahoo.com

Үндсэн хэсэг

Монгол хувцсыг судалсан байдлыг тоймлон авч үзвэл Г.Бадрах монгол эртний хувцасны хэв загварыг, Х.Нямбуу (2002), Г.Батнасан (1989), Д.Сономцэрэн (1985) нар монгол хувцсыг түүх, угсаатны зүйн талаас, С.Бадамхатан (2002, 2004) олон ястны хувцасны онцлог талаас, Д.Баяр (2004) XIII зууны дээлний онцлог хүн чулууны дурсгалд хэрхэн дүрслэгдсэн талаар, Б.Доржсүрэн (1961) археологийн олдвор, эртний Хүннүгийн үеийн хувцсыг эдийн соёлын талаас, Г.Цэрэнханд (2005) монголын эртний хувцасны талаар, Б.Дунгаамаа (2004) монгол дээлний эсгүүр гаргах үйл явцыг, Н.Норжинхорлоо (2004) их дээд сургуульд дээл эсгэх хийх арга зүйг, Ч.Сонгино (1989, 1999, 2000), О.Өнөрмаа (2012) нар үндэсний хувцас хийх уламжлалт технологийн сургалтын арга зүйг, Т.Дисан (1999), А.Оюунтунгалаг (2004), А.Баасанхүү (2006) нар монгол үндэстэн ястнуудын дээл, хувцасны өвөрмөц онцлогийн талаар, Л.Сономцэрэн (1992) эдийн соёлын талаас, Данийн эрдэмтэн Хэнни Хэрлод Хансэн²³ (1960) угсаатны зүйн талаас судалжээ. Мөн ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Угсаатан судлал” цуврал болон Өвөрмонголын “Монгол зан аал” цувралд олон монголчуудын зан заншил, эд өлгийн соёл, хувцас заслын тухай дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

Эрдэмтэн Х.Нямбуу (2002, х.45) хувцасны түүхийг судлаад “монголчууд эртнээс нааш хувцасны тухай хууль гаргаж, харьяат улсын дотор журамлан мэдүүлж, даган мөрдүүлсээр иржээ. Монгол газар анхны төр байгуулсан Хүннү нар өөрийн хувцасны хуультай байсан. Монголын эзэнт гүрний цагт их хаан Мөнх 1252 онд, Хубилай 1275 онд тус тус хувцасны тухай хууль гаргаж, хувцасны хэв маягийг тогтоожээ. Хубилай хааны үед монгол язгууртны хувцасны загварыг ноёд түшмэдийн гол маяг болгон “зүсмийн хувцас” гэдгийг бий болгожээ. Юань улсын сударт тэмдэглэгдсэн жисүн гэгч нь монгол хэлний зүс хэмээх үг болой хэмээн монгол хувцсыг хэд хэдэн зүйлд ангилж, үндэстэн ястны хувцасны онцлогийг тодорхой өгүүлжээ.

Богд хаант улсын үед гаргасан “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн Ёслолын бүлэгт (*Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг*, 2010, х.105) ван гүн, ноёд түшмэд, лам нарын жинс, дээл, дэвсгэр, лам нарын өмсгөл хувцасны өнгө, хэлбэрийг, тус бичгийн Бат оршил өргөх ёслолын хуульд (*Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг*, 2010, х.123) аливаа ван гүн, түшмэд жич хэргэмтэн лам нарын ёслолын өдөр өмсөх дээлний нударга ба малгайн хүрмийг цаг улирлыг дагаж хэрэглэх хууль, мөн өвлийн дунд сарын шинийн нэгнээс цагаан сарын арван таван

хүртэл ёслолын өдөр өмсөх хувцасны хууль гаргаж малгай тэргүүтэй хувцасны өнгө хийцийг нарийн жагсаасан зэрэг нь энэ үеийн албаны хувцасны дүр төрхийг ойлгох гол баримт болно.

1930 онд угсаатны зүйч Г.Бадрах XIII зуун хүртэлх үеийн монгол хувцасны тухай хэрэглэгдэхүүн цуглуулж, “Монгол хувцасны эртний өгүүлбэр” хэмээх зохиол туурвиж, үүндээ Кидан, Юань улсын үеийн хувцасны тухай сонирхолтой баримтыг мэдээлсэн байна. Энэхүү бүтээлийг судлаач Б.Сувд “одоогоос 70 гаруй жилийн өмнө Г.Бадрах, Б.Соёлтой нар худам монгол бичгээр 95 хуудас, нэн гаргацтай, цэвэр нямбайлж бичсэн, хавтаслаж хамгаалсан, бүлэг дотор түүний анги, бичсэн зүйлээ оноосон нэртэй, дэс дугаарлан үйлдсэн бүтэц зохион байгуулалтай, хавсралт хэсэгт алдарт зураач Б.Соёлтой эртний монгол хувцасны зургийн цоморлог үйлдсэн нь уг хувцасны дүрс маягийг гаргасан нэн сонирхолтой бүтээл болсон төдийгүй хожмын судлаачдын сонирхон үздэг ховор нандин гар бичмэлийн нэг юм” (*Дээлтэй Монгол эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, 2010, х.135) гэж онцолсон байна. Б.Сувд 2008 онд угсаатны зүйч, доктор Г.Батнасангай хамтран уг эхийг сэргээн уйгаржин монгол бичиг болон англи хэлээр хадмал орчуулгатай дахин хэвлүүлжээ.

Судлаач Д.Баяр Монголчуудын XIII-XIV зууны үед холбогдох хүн чулууны хөшөө дурсгалд тухайн үеийн хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан хувцас, гоёлын зүйлийг хэрхэн дүрсэлснийг судалж хөшөөн дэх “дүрсэлбэрийг” (Баяр, 2012, х.51) малгай, дээл, гоёл чимэглэл гэж төрөлжүүлсэн судалжээ.

Эрдэмтэн Г.Батнасан (1989, х.53) монгол угсаатан ястны түүхэн хөгжил, амьдралын хэв заншил, байгаль цаг уурын онцлог, эрхлэх аж ахуй зэрэг өөр өөр байдаг тул тэдний өмсөх хувцас хэрэглэл ч бие биеэс ялгаатай байгааг судалж, халх, ойрд, буриад, үзэмчин ардын хувцас, гоёл чимэглэлийн зүйл, мөн үндэсний бөхийн хувцас, хүүхдийн хувцасны онцлогийг угсаатан зүйн талаас судалж, хувцасны төрөлд холбогдох зарим нэг зан үйлийн тухай тэмдэглэжээ. Тухайлбал, “хүүхдэд шинэ дээл, тэрлэг хийж өмсгөхөд өглөөний улаан нарнаар сүүлчийн учиг хатгаад, үр хүүхдэдээ бэлэгтэй ерөөл хэлж, урд, хойд хормойд нь өрөм зөөхий гүрхэж, дотоод хормойг нь тос өөхөөр мялаана. Хүүхдэд зориулан хийсэн тэрлэгийг эхлээд гэрийн хаалганы хатавчинд хүргэж хөдөргөсний дараа өмсгөнө. Энхрий эрэгтэй хүүхдэд буруу энгэртэй дээл, эрэгтэй хүүхдэд авгай дээл, тэрлэг хийж өгдөг ёстой. Тэгэхдээ тоосонд бүү хүр, тосонд бүү хүр, хуранд бүү хүр, хуриманд бүү хүр хэмээн бэлгэдэн хойд, урд хормойноос нь гурав гурав дугтраад өсгөнө. Шөнийн цагаан гэгээ тасрах үеэр хүүхдэд шинэ хувцас өмсгөж, эмэгтэйд зүү, утас, харин хөвүүнд

²³Henny Harald Hansen

эмээлийн жирэм, уургын хуйв хийх сур өгдөг заншилтай байсан нь Монголчуудын эрхлэх аж ахуйн онцлогийг илэрхийлнэ гэжээ. Мөн 2002 онд дархад ястан, цаатан ардын дунд угсаатан зүйн судалгаа явуулж, нэг сэдэвт бүтээл (Батнасан, 2002) туурвиж, дархад ястны дээлний үүсэл гарал, түүх, дархад бөөгийн хувцас хэрэглэлд холбогдох зан үйлийн тухай олон сонирхолтой баримтад тулгуурлан судалжээ. 2004 онд боржигны халх, хотон, ойрд, алтайн урианхай, мянгад ястны түүх, зан заншил, эд өлгийн соёлыг дэлгэрэнгүй өгүүлсэн бүтээл (Батнасан, 2004) туурвиж хувцас, гоёл чимэглэлийн онцлогийг тусгажээ.

Эрдэмтэн Ч.Сонгино үндэсний хувцас, хэрэглэлийг урлах, хийх үйл урлалын талаар нарийвчлан авч үзэхдээ хүн хувцас, эдлэл хэрэглэх болсон цаг үеэс эхлэн амьдралын хэрэгцээ шаардлагаас ургамлын зүйлийг сүлжих, ан амьтны арьсыг нөмрөх, дэвсэх, хучиж хулдах зэрэг үйл нь улам боловсронгуй болж өнөөгийн хувцасны хэв шинжийг олсон талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Тэр цаг үеэс хувцас эдлэлийн эсгүүр бий болж, оёх, шидэх, сүлжих, эрчлэх, томох гэх мэт үйл урлалын олон төрөл бий болсныг дурдаад энгийн болон гоёл чимэглэлийн гэсэн оёдлын хоёр төрлөөр хэрхэн хувцас, эдлэл хийх аргыг дэлгэрэнгүй өгүүлжээ. Тэрээр монгол уламжлалт арга ухаанд үйл урлахад маш олон төрлийн нэр бүхий аргууд байгааг нэг бүрчлэн дэлгэрэнгүй тайлбарлаж энгийн оёдлын ширэх, нэвтгэлзэн ширэх, үргэлж хавах, хийлж хавах, товших, шидэх, үдэх (1999, х.122-126) гэх мэт 20 гаруй нэр төрлийг, гоёл чимэглэлийн хатгамал, хонин холбоо, чагтан хэрээс, шүдлэг олсны эрч, загасан нуруу, шаглаас, туулай харайлгах, тагнайлдах, шивүүр гэх мэт 40 гаруй төрөл байгааг дурджээ. Мөн зангилааны цацаг зангилаа, аман хүзүү зангилаа, моголцог зангилаа, бэл цэцгэн зангилаа, олбог зангилаа, занги зангилаа, хулз зангилаа, цулбуур зангилаа гэх 20 гаруй төрөл, сүлжмэлийн зоосон сүлжээ, гяраг сүлжээ, цоолбор сүлжээ, буйлан сүлжээ, товцог сүлжээ (1999, х.280-286) гэх мэт 29 нэр төрлийг дурдаж эдгээрийг хэрхэн сүлжих, зангилах, оёх хийгээд хувцас урлах аргын тухай өгүүлсэн байна. Эдгээр оёх, зангилах үйлийн нэр томъёог хэл, соёлын олон уулзвараас судлах зайлшгүй шаардлагатай юм.

Мөн эрдэмтэн Ч.Сонгино (1989, х.73) хувцас урлахад цээрлэх ёсон, билэгдэлт үг хэллэгийн уламжилсан байдал, зарим хувцсыг хийхтэй холбогдох домог, ярианы тухай цухас дурджээ. “Хувцас хийж байгаа эмэгтэй хүнтэй дайралдахад “үйл бүт” гэж ерөөдөг байсны зэрэгцээ эмэгтэй хүнд өв тэгш, сайн сайхан аж төрөхийн билигтэй ерөөлийг дэвшүүлэхдээ “үйлэнд уран, үгэнд цэцэн яваарай” хэмээн ерөөхөөс эхлэн олон арван билигт сайн ерөөл,

домог хууч байдаг гэх мэтчилэн зан үйлийн холбогдлыг тайлбарласан байна.

Урлаг судлаач А.Баасанхүү Монгол Алтайн бүс нутагт аж төрж байгаа олон ястны эдийн соёлын зүйлийг бодит баримтад тулгуурлан судалж, Алтайн бүс нутагт суугаа ястнуудын эдлэл хэрэглэлийн соёлыг дэлгэрэнгүй үзүүлсэн цомог бүтээж, хавсралт хэсэгт хувцас, эдлэл хэрэглэлтэй холбоотой зарим үг хэллэгийг бүс нутгийн ард түмний аман ярианаас тэмдэглэн авч, тайлбар хийжээ. Тэрээр халх эхнэрийн нэгэн төрлийн дээлийг “Баруун халх эхнэр сааль сүүний болоод энгийн үед босоо захтай, даруухан хийцтэй, ганц товч шилбэтэй, төв маягийн уртавтар, түнтгэр мөртэй “дэнхэвтэй дээл” дээл өмсдөг.” (Баасанхүү, 2006, х.6). “Дэнхэв гэдэг нь халх, мянгад эхнэрийн дээлний урд талын бүсэлхийний хэсэгт гаргасан чимэглэл бүхий даруулга. Энэ нь гоёл чимэглэлийн төдийгүй хүний биеийн эрчим хүчний эх үүсвэрийн харалдаа байрлаж байгаагаараа хүйтэн сэрүүн бүс нутагт оршин суугчдын биеийн дотоод дулааныг барьж байх зориулалттай” (Баасанхүү, 2006, х.226) гэжээ. Дэнхэв буюу дэнхэвтэй дээлний тухай толь бичгүүдэд тэмдэглэн тайлбарласан зүйл байхгүй байна. Тиймээс Баруун монгол ястны дээл хувцасны бүрдэл хэсэгт “дэнхэв” гэсэн хэллэгийг анх удаа тэмдэглэсэн гэж үзэж болох юм.

Мөн судлаач Ж.Баясах Их Монгол улсын түүхэнд холбогдох “Монгол татаарын бүрэн тэмдэглэл” (Мэнда бэйлү), “Хар татаарын хэргийн товч” (Хэйда шилюэ) хэмээх хятад хоёр сурвалж бичгийг МНТ болон бусад түүхэн сурвалжтай харьцуулан судалж, XIII зууны эхэн үеийн монголчуудын хоол хүнс, хувцас хунар, унаа хөсөг, ахуй амьдрал, оюуны соёлын зарим төрөл зүйл, уламжлалт зан үйл, ёс заншлын талаар хэрхэн тэмдэглэснийг өгүүлжээ. “Хар татаарын хэргийн товч” сурвалжид Монголчуудын хувцасны талаар “гэдний гадуур хувцас зүүнээсээ баруун тийшээ энгэр нь зөрдөг бөгөөд энгэр нь дөрвөлжин... дээлний өнгө нь улаан, нил ягаан бас ногоон байдаг ба бөс даавуун дээр нар, сар, луу, хангарьдын дүрстэй” хэмээсэн нь Монголчуудын хувцасны энгэр зах босоо дөрвөлжин байдаг нь ХҮШ зуунаас хойш Манжаас улбаатай гэдгийг няцааж байна (Баясах, 2005, х.81) гээд “Монгол татаарын бүрэн тэмдэглэл” сурвалжид богт малгайн талаар өгүүлснийг “тэдний дээдсийн эхнэрүүд гу-гу малгай өмсөнө. Тэр нь гурав гаруй тохой өндөр, улаан хүрэн өнгийн гар хатгамалтай торго буюу сувд алтаар чимнэ” гэсэн бол эрт үед монголын нутгаар аялсан жуулчдын тэмдэглэлд бокка малгайн тухайд “эрд гарсан эмэгтэйчүүд богта хэмээх модны холтос өөр ямар нэгэн хөнгөн эдээр хийсэн хоёр гардаж л барьж болохуйц том хэмжээтэй толгойн өмсгөлтэй бөлгөө. Их авхай хатад нар энэ өмсгөлөө тогосны өд, нугасны

бяцхан өдөөр чимэглэнэ” гэснээс үзвэл эрд гарсан эмэгтэйн малгайг бокка, богта, гу гу гэх мэт өөр өөр тэмдэглэсэн боловч угтаа нэг малгайн тухай бичсэн тодорхой юм. Тэд малгайн нэрийг бокка хэмээн буруу галигласан байж магадгүй юм” (Баясах, 2005, х.86) гэжээ. Орчин цагийн монгол хэлэнд богтлох гэсэн үг байдаг нь “богт өмсүүлэх буюу” “эрд гаргах” гэсэн утгатай бөгөөд үүнээс “богта малгай” (богтог малгай) гэсэн нэрийн гарал түүхийн холбогдол байж болох юм.

Эрдэмтэн Ш.Гаадамба “МНТ-нд гардаг богта хэмээх үгийг “богта (га)(лажу), богтог малгай өмсөх гэсэн энэ үгийг хятад галиг үсгээс Хэниш “богтагаху” гэж сийрүүлээд “толгой самнах” гэж хадмал хятад үгийн орчуулгыг тайлжээ. Бид энэ үгийг хүзүүгээ гойхоотол үсээ шууж (богтогдож) богтага малгайдаа хийж гэсэн утгатай үг” (Гаадамба, 2016, х.39) гэж тайлбарласан байна.

Эрдэмтэн С.Бадамхатан “малгайн тухайд авч үзвэл төв болон зүүн монголчууд шовгор, гозгор оройтой, харин баруун монголчууд намхавтар гозгор оройтой малгай өмсдөг байсан бөгөөд малгайн оройгоор сүмбэр уулыг төлөөлүүлэн түүнийг тойрсон 32 хамар ширээсийг сүмбэр уулыг түшин аж төрөх монгол ястан хэмээг домоглодог бол монголчуудыг гийгүүлэн буй алтан шаргал нарны туяа нь малгайн оройгоос унжсан залаа гэдэг. (“Аман зохиол судлал”, 13-р боть, 1986, х.169) Эрдэмтэн Х.Нямбуу “хилэн малгайн хүрээг тойруулсан хар хүрээг монгол орныг бүсэлсэн харь дайсан бөгөөд малгайн ар талын сэтэрхий тасархайг монголчуудад хэзээ нэгэн цагт умар зүгээс сайн санаат ахан дүүс тусламж үзүүлэн монгол хүний баярын магнай тэнийн сэтгэлд нь галын дөл мэт цацран бадарч усан долгион мэт мяралзана гэж үзэн хөх, улаан өнгийн хос бүч унжуулан хадаж гоёдог байна. Ард түмэн үүрдийн жаргалан ирэхийг билэгдэж хос бүч хаддаг” (Нямбуу, 1968, х.18) зэрэг малгайн тухай болон билэгдэлт утгын талаар олон эрдэмтэд тэмдэглэсэн байна.

Доктор С.Дулам “малагай” гэх үгийн гарлыг орчин цагийн монгол хэлний “халзан” хэмээх үгтэй холбон тайлбарлаж, үлгэр туульсын баатруудын малгайн утга билэгдлийг тодруулж, эртний “богтог” малгай, монгол “шовгор” малгай, торгууд ястны “тоорцог” малгайн утга билэгдлийг тайлбарласан өгүүлэл бичжээ.

Судлаач Б.Амаржаргал (2007, х.208) “бичгийн хэлний “малгай” гэдэг нэрийг халх аялгуунд олон үгээр ялгаж нэрлэнэ. *Öwüdz* (оовууз), *owödböe* (овоодой)-өндөр оройтой, хагас дугуй хэлбэртэй, үстэй малгай, *owölböe* (овоолой)-хурдан морины хүүхдийн малгай, *tag* (tag)-өвлийн малгай, *tewxü'dz* (тэвхүүз)-саравчтай малгай, *törtsog* (тоорцог)-ширмэл бүс малгай, *esgī* (эсгий), *sīrsen* (сийрсэн), *üne-gen* (үнэгэн), *xurγan* (хурган), *tsāsan* (цаасан) гэх

мэтээр ярина хэмээн нүүдэлчин малчдын эдэлж хэрэглэдэг хувцасны нэр нь маш өвөрмөц байгааг “малгай”-н жишээгээр тайлбарласан байна.

Мөндоктор С.Дулам монгол хэлний хэвнэг, нэмнээ гэх хоёр үгийн гарлыг Өвөрмонголын “дөрвөн хэлний гүүш”, монгол хэлний багш Лувсанчойдон “Монголын зан айлын ойлбор” (1915-1918) хэмээх номдоо “Монгол удмын эртний цагт эхлэн дээл хувцас өмсөх юм “нэмэ” хэмээх нэгэн зүйлийн юмаар биеэ ороож явав... Харин нэмэ болоод гөрөөсөн арьсыг дээл болгож өмссөн газар олон буй” хэмээсэн баримтад тулгуурлан тайлбарласан байна. (“Дээлтэй Монгол” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2010, х.13) Эрдэмтэн Л.Дашням монгол хувцасны зүйл болох “унжлага, манжлага” хэмээх хоёр үгийн гарлын “бөх” хэмээх үгийн гаралтай холбон тайлбарлажээ. (*Дээлтэй Монгол*, 2010, х.25)

Өвөрмонголын эрдэмтэн О.Тайван (“*Ойрад судлал: угсаа, хэл, соёл*, 2015, х.45”) өөлд, торгууд ястны “бишимэд” хэмээх хувцасны гарал үүслийн талаар түүх, угсаатны зүйн олдвор болон Жангар туульд хэрхэн өгүүлсэнд үндэслэн тайлбарлажээ.

Доктор Б.Амаржаргал (2007, х.83) халх аялгууны хувцас, аж байдал, эд агуурс, үйл хөдлөлийн холбогдолтой 252 ижил дуудлагатай үг, 53 ойролцоо утгатай үг хэллэгийг статистик аргаар харьцуулан авиа зүй болон үгийн сангийн зөрөөтэй үг хэллэгийг түүвэрлэн гаргажээ. Түүний жишээнээс хувцас хэрэглэлтэй холбоотой үг хэллэгийг тодруулбал, *boᠭᠦ* гэдэг үг нь сартуул аман аялгуунд сампин, мөн дээлний зангидсан товч гэсэн хоёр утгатай, *oᠭᠲᠦᠭᠦ* гэдэг нь дээлний зүйдэл (Tkha), уулын бэл (Go), унины бөгс (Sü), будлиан самуурал (Tkha), гажуу зан (Tha), *tag* гэдэг үг нь өвлийн малгай (Tkha., Gka), таглаа (Tkha), уулын орой (Tkha), огт чимээгүй (Tkha) гэх мэт өөр утгатай ижил үг байгаа тухай өгүүлжээ.

Б.Амаржаргал (2007, х.76) “халхын салбар аман аялгуунд зарим хувцасны нэрийг янз бүрээр нэрлэдэг. Дээлний болон бусад төрлийн эмжээрийг *boᠭotšo* (Dg), *dzēg* (Sar), *endžēr* (Gkha), *xiadz* (Tkha), *xerwē* (Dar), *xurūᠯa* (Dar), *mandžā* (Min), *tasam* (El, Sar), янз бүрийн гутлын нэрийг аман ба салбар аман аялгуунд *ātankā* (Dar), *bōew* (Dkha), *sar'stā* (El), *tandatmā* (Ü-хүндэтгэлийн утгаар) гэх мэт. Хүүхдийн өмдийг *bādaē* (Dun), *bariwtšī* (Ar, Ba), *düdü* (Ü), *mayay* (Öl) гэх үгийн сангийн зөрөөтэй ойролцоо утгаар нэрлэж байна. Ингэж ойролцоо утгаар нэрлэхдээ зарим зүйлийг өөр юмтай жишин харьцуулсан хэмээн эмжээр гэдэг үгийн ойролцоо утгыг гаргажээ. Мөн элжигэн халх аялгуу болон төв халхын аман аялгууны үгийн сангийн зөрөө нь ард түмний өдөр тутмын ахуй амьдралын элдэв зүйлс, эдэлж хэрэглэдэг эд юмс, хүний гоёл

чимэглэл, хувцасны нэр дээр тохиож байгааг dz-uwtsā-нимгэн үстэй дээл, pārtag- дэгтий гэх мэт хувцасны холбогдолтой үг хэллэгийн жишээгээр батлан тайлбарласан байна.

Эрдэмтэн М.Базаррагчаа (1995, х.135) “Хүний биеийн өмсгөлийг хувцас (кубчасу) гэнэ. Монгол бичгийн хэлнээ хувцсыг кубчасун, кубча-н кубча-д гэх ба ховчис (барга, харчин, түмэд), ховтос (хорчин), хувшад (жалайд дөрвөд), хувтас (халх), хувдас (захчин, торгууд, баяд), гувцас, увцас (барга, баруун халх) гэх мэтээр хэлэлцдэг (Ж.Цолоо “О некоторых названиях монгольской одежды. “Монгольский лингвистический сборник. М, 1992, Х132)” тухай дурдаад “хувцас” хэмээх үгийн авианы сэлгэцээр үүсэх хувилбарыг гаргасан байна.

1966 онд ардын зураач Ү.Ядамсүрэн монгол олон ястны хувцас гоёлын тоймыг зурахдаа Богд Жавзандамбаас эхлүүлээд хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг, бичиг цэргийн болон лам, түшмэд, цагдаа, мяндаг тушаалтан, баян хүмүүсийн хувцас гоёл, Монгол цамын баг өмсгөлийг бүрэн зурсан байна. Мөн Төрийн шагналт, ардын зураач Г.Одон монголын Дорнод нутгийн буриад ястны хувцас чимгийг судлан цуглуулж, “Буриад ардын хувцас гоёл, чимэглэл, эдлэл хэрэглэл” хэмээх гар зургийн цомог, М.Амгалан Ойрад Монголчуудын олон ястны хувцсыг “Баруун монголчуудын эдийн соёлын дурсгал” цомог, А.Баасанхүү “Монгол Алтайн бүс нутгийн ард түмний эдийн соёл” зургийн цомогтоо дэлгэрэнгүй зурж үзүүлжээ.

Дүгнэлт

Эрдэмтдийн судалгааг ерөнхий гурван ангилалд хуваан үзэж болохоор байна.

Үүнд:

1. XIII зуунаас ч өмнө эдэлж хэрэглэж байсан монгол үндэсний хувцасны өвөрмөц онцлог, хэв загвар, ёс дүрэм, олон үндэстэн ястны хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, эдлэл хэрэглэлийн онцлог, түүхэн хөгжлийг эртний хүн чулууны дурсгалууд болон түүхэн сурвалж бичигт тэмдэглэснээр баяжуулан судалсан түүх, угсаатны зүй, археологийн судалгаа;
 2. Монгол үндэсний хувцсыг үлгэр, загвар зохион эсгэж оёхоос эхлээд уламжлалт болон орчин үеийн эсгэж оёх үйлийн олон нэр төрөл, аргачлал, багаж хэрэгсэл, тэдгээрийн үүрэг зориулалт гэх зэрэг үйл урлахуйн талаас судалсан судалгаа;
 3. Хэлний тэмдгээр соёлын зүйлийг илэрхийлэн уламжлуулсан байдал хийгээд хувцасны олон зүйл нэрийг утга, билэгдэл, гарал зүйн талаас судалсан судалгаа;
- Эдгээр судалгаанаас эрдэмтэд түүх,

угсаатны зүй, археологийн болон үйл урлахуйн талын судалгааг нэлээд дэлгэрэнгүй хийжээ. Харин хувцасны олон төрлийг оноон нэрлэсэн нэрийн зүйлд холбогдох хэл, соёлын талын судалгаа ховор байна.

Аливаа ард түмний хувцас нь эдийн соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг болохын зэрэгцээ түүнийг нэрлэсэн хэлний үгийн сангийн нэгжүүд нь тухайн ард түмний аж амьдрал, түүх, соёл, зан заншлыг өөртөө хураан шингээсэн онцлогтой байдаг. Иймд олон төрлийн хувцас, гоёл чимэглэлийн нэр, олон төрлийн оёх мэтгэх үйлийн нэр зэргийг хэл, соёлын харилцан хамааралд нь, хэлний үгийн сан, үгийн гарал зэрэг олон талаас судлах шаардлагатай юм.

Ашигласан материал

- Амаржаргал, Б. (2007). *Халх аялгууны үгийн сан, утгын судалгаа*. Улаанбаатар
- Баасанхүү, А. (2006). *Монгол Алтайн бүс нутгийн ард түмний эдийн соёл*. Улаанбаатар
- Бадамхатан, С. (2002). *Эрдэм шинжилгээний бүтээлүүд*, I. Улаанбаатар: Соёмбо принт
- Бадамхатан, С. (2004). *Эрдэм шинжилгээний бүтээлүүд*, II. Улаанбаатар: Соёмбо принт
- Базаррагчаа, М. (1997). *Монгол үгийн гарлыг мөшгих нь*, III. Улаанбаатар
- Батнасан, Г. (1989). *Монгол ардын хувцас*. Улаанбаатар
- Батсайхан, О., Лонжид, З., Хажидсүрэн, Ч., (2010). *Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг*, Улаанбаатар
- Баяр, Д. (2004). *Хүн чулуун хөшөөнд дундад зууны монгол эмэгтэйчүүдийн хувцас гоёлыг дүрсэлсэн нь*, Улаанбаатар
- Баясах, Ж. (2005). *Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг*. Улаанбаатар
- Гаадамба, Ш. (2016). *Монголын Нууц Товчооны үг хэллэгийн тайлбар*, ШУА, ХЗХ. Улаанбаатар
- Нямбуу, Х. (2002). *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар: Адмон принт
- Нямбуу, Х. (1968). *Хамгийн эрхэм ёсон*. Улаанбаатар
- Үндэстний хувцас судлалын академи, Монгол костюмс төв. (2010). *Дээлтэй Монгол эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.
- Сонгино, Ч. (1999). *Монголчуудын үйл урлахуйн эрдэм, ухаан*. Улаанбаатар:
- Сонгино, Ч. (1989). *Монгол эмэгтэйн уран үйл*. Улаанбаатар.
- ШУА, ХЗХ, (1986). *Аман зохиол судлал, 13-р боть*. Улаанбаатар.
- Ядамсүрэн, Ү. (1966). *БНМАУ-ын үндэсний хувцас*. Улаанбаатар.